



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2025/113/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2023 он	Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Ахлах аудитор: Г.Намчинсүрэн Утас: 70342716
	Цахим хаяг: Erdeneb@auditgov.mn Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Аудитын санал дүгнэлт



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.03

№

26

танай

ны №

т

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Г.АНГИРМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Шүүхийн тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Шүүхийн тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Тухайн байгууллагын хувьд тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.12 -д хязгаарлалтад хамрагдаагүй.

Шүүхийн тамгын газрын 1 хөтөлбөр, 6 арга хэмжээний хүрээнд нийт 2,374.2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 2,293.0 сая төгрөгийг зарцуулж хөтөлбөр, арга хэмжээний биелэлт 97 хувьтай байна.

Жилийн эцсээр 107.3 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн

006020061

дүгнэлт гаргаагүй болно.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 117 дугаар тогтоолоор бүх шатны шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг 5 дугаар хавсралтаар шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор шүүгчийн цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 69 хувиар өссөн байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ



Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	20,198.0	25,980.1
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	766,115.0	819,780.3
	Нийт хөрөнгийн дүн	786,313.0	845,760.4
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	786,313.0	845,760.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	786,313.0	845,760.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,639,258.9	2,606,206.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,672,543.3	2,597,340.6
	Үйл ажиллагааны үр дүн	(33,284.4)	8,866.1
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(33,284.4)	8,866.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	773,366.8	786,313.0
	Тайлант оны үр дүн	12,946.2	59,447.4
	Эцсийн үлдэгдэл	786,313.0	845,760.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,628,211.9	2,596,201.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,593,846.3	2,526,469.2
	Үйл ажиллагааны ЦМГ	34,365.6	69,731.9
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(26,072.5)	(80,135.8)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	8,293.0	(10,403.9)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,840.0	12,020.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,020.0	1,616.1
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	2,421,665.8
	Урсгал зардал	-	2,421,665.8
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	2,421,665.8
	Улсын төсвөөс санхүүжих	-	2,421,665.8
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шүүх нь Монгол улсын тусгаар тогтнол бүрэн эрхт байдал, Үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлж хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, хууль дээдлэх, шударга ёсыг бэхжүүлэх, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах эрхэм зорилготой.

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газар нь шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд хөндлөнгөөс оролцохгүйгээр шүүгчийн хараат бус байдлыг хангаж хамгаалах, шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах, шүүхийн хүний нөөцийг удирдах, шүүхийн төсөв санхүү, дэд бүтцийг удирдах, шүүхийн нээлттэй байдлыг хангаж олон нийттэй харилцах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Булган аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Булган аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүх, Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Булган аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх болон тамгын газарт нийт 10 шүүгч, 27 шүүхийн захиргааны ажилтан тус аймгийн 16 сум, 1 тосгоныг харьяалан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус шүүхийн тамгын газар нь 2024 онд Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга, төсвийн ерөнхийлөн захирагчтай 58 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулан “Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх” зорилтыг дэвшүүлэн, хэрэгжилтийг ханган 94,1% гүйцэтгэлтэй байна.

Тав. Аудитын илрүүлэлт.

Аудитаар нийт 2,264.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс 2,264.8 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын дансанд бүртгэлтэй 3 нэр төрлийн нийт 2,264.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэлтэй байгаа нь санхүүгийн тайлангийн аудитын ангилал батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын дансанд бүртгэлтэй 3 нэр төрлийн нийт 2,264.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг Сангийн сайдын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/229 дүгээр тушаалын хавсралтын дагуу зөв ангилан бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 07 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шүүхийн тамгын газар	1	2,264.8			1	2,264.8			1	2,264.8		
Дүн	1	2,264.8	-	-	1	2,264.8	-	-	1	2,264.8	-	-